



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/49

Амардалай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1.13, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.7, 32.1.9, 32.1.10 Байгалийн ургамалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Засгийн газрын 2019 он 05 дугаар сарын 01-ны өдрийн "Бэлчээр хамгаалах өдөр" 185 дугаар тогтоол, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн А/143 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үлийн цагаан оготготой микробиологийн аргаар тэмцэх ажлыг 2023 оны 05 дугаар сарын 01-10-ны өдрүүдэд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Баттогтох (Хөдөө аж ахуйн мэргэжилтэн)

Гишүүд: Б.Баатарсүрэн (3-р багийн Засаг дарга)

Г.Сосорбурам (3-р багийн Засаг дарга)

Б.Довуучий (2-р багийн Засаг дарга)

Д.Цэнд-Аюуш (1-р багийн Засаг дарга)

2. Тус ажлыг зохион байгуулахад гарах унаа, шатахуун, хөдөлмөр хамгааллын зардлыг Засаг даргын нөөц сангийн зардлаас гаргахыг нягтлан бодогч (Г.Дэжидсүрэн)-д зөвшөөрсүгэй.

3. Малчид, иргэдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг нарийн чанд мөрдүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, ажлын явцад хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ